



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 05 сарын 31 өдөр

Дугаар А/139

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын в, д, Засгийн газрын 2008 оны 11 дүгээр тогтоолоор батлагдсан журмын 3.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.5, 32.1.10, 34 дүгээр зүйлийн 34.2.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 30.1 дэх заалт, Улсын Онцгой комиссын 2020 оны 12 дугаар хурлын тэмдэглэлийн 7.1 дэх заалт, аймгийн Онцгой комиссын 2020 оны 8 дугаар хуралдаанаас гарсан шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийгмийн халамж, дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай эмзэг бүлгийн иргэдийг хоол хүнсний дутагдлын эрсдэлээс хамгаалах, гамшиг, онцгой нөхцөл дэх хүн амын хоол хүнсний хэрэгцээг хангах, (COVID-19) өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн хамгааллын үйлчилгээг хэрэгжүүлэхэд 120.000.000 (нэг зуун хорин сая) төгрөгийн хоол хүнсний дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх зардлын 74.000.000 (далан дөрвөн сая) төгрөгийг Гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр), 16.000.000 (арван зургаан сая) төгрөгийг аймгийн Онцгой комисст өгсөн хандив, тусламжаас гаргахыг аймгийн Онцгой байдлын газар (дэд хурандаа Т.Мөнхдорж), 30.000.000 (гучин сая) төгрөгийг нийгмийн халамжийн сангаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын дэргэдэх Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар (С.Ундрах)-т тус тус зөвшөөрсүгэй.

3. Коронавируст халдварын сэжигтэй тохиолдол гарсан үед хязгаарлалтын дэглэмд ажилласан нэр бүхий 18 алба хаагчдад нэмэгдэл хөлс тооцож, алба хаагчдад олгох 5.691.160 (таван сая зургаан зуун ерэн нэгэн мянга нэг зуун жар) төгрөгийн зардлыг нэгдүгээр хавсралтаар баталж, Гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

4. Шинэ коронавируст халдварын үед нэн шаардлагатай тоног төхөөрөмж авахад шаардагдах 69.250.000 (жаран есөн сая хоёр зуун тавин мянга) төгрөгийн зардлыг хоёрдугаар хавсралтаар баталж, Гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

5. Тоног төхөөрөмж худалдан авах ажиллагааны талаар байгууллага, аж ахуйн нэгжүүдээс үнийн санал авч худалдан авалт хийхийг аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газар (Д.Шивааннүрдэв)-т даалгасугай.

011100302

2.

6. Хүнсний дэмжлэгийг сумдад олгох хуваарийг 2020 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн дотор батлуулж, захирамжийн хэрэгжилтэд хяналт ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (И.Доржсүрэн)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

Аймгийн Засаг даргын 2020 оны 03
дугаар сарын 31-ны өдрийн 139 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

КОРОНАВИРУСТ ХАЛДВАРЫН СЭЖИГТЭЙ ТОХИОЛДОЛД АЖИЛЛАСАН
АЛБА ХААГЧДАД НЭМЭГДЭЛ ХӨЛС

Д/Д	Нэрс	Албан тушаал	Үндсэн цалин	4 хоног	А/О НДШ	Тооцон олгох хөлс
1	Ч.Золзаяа	НЭМХ-н дарга	924,456	348,851	43,606	392,458
2	Ч.Эрдэнэтуяа	Халдвартын их эмч	818,762	308,967	38,621	347,588
3	Д.Цэндхорол	Ариутгагч	740,619	279,479	34,935	314,414
4	Г.Мөнхсайхан	Жолооч	587,385	221,655	27,707	249,362
5	Г.Надмидсүрэн	Тархвар судлаач	842,702	318,001	39,750	357,751
6	Г.Отгонсүрэн	Халдвартын сувилагч	723,450	273,000	34,125	307,125
7	Х.Энхсүрэн	Халдвартын үйлчлэгч	487,695	184,036	23,004	207,040
8	Н.Өлзийхутаг	Ахлах байцаагч	876,151	330,623	6,612	337,235
9	Ч.Мөнх-Эрдэнэ	Цагдаа	634,736	239,523	4,790	244,313
10	Г.Банзрагч	Цагдаа	634,736	239,523	4,790	244,313
11	Н.Намхайнямбуу	ГХТББХАМ, ГХУХБайцаагч	951,344	358,998	7,180	366,178
12	Б.Өлзий-орших	Аврагч гал сөнөөгч	746,085	281,542	5,631	287,172
13	Г.Нямсүрэн	Аврагч гал сөнөөгч	594,989	224,524	4,490	229,015
14	С.Сосорбурам	Лабораторын их эмч	912,097	344,188	43,023	387,211
15	Л.Мэнд-Амар	Тархвар судлалын тасгийн эрхлэгч	799,806	301,814	37,727	339,540
16	С.Хоролмаа	Лабораторийн эмч	842,702	318,001	39,750	357,751
17	О.Жамъяанжав	Ариутгагч	740,619	279,479	34,935	314,414
18	Б.Гончигсүм	Жолооч	547,509	206,607	25,826	232,433
Нийт дүн			13,405,843	5,058,809	632,351	5,691,160

Аймгийн Засаг даргын 2020 оны 03
дугаар сарын 31-ны өдрийн 1139 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт

ШИНЭ КОРОНАВИРУСТ (КОВИД-19)-ИЙН ХАЛДВАРЫН ҮЕД НЭН
ШААРДЛАГАТАЙ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ТООЦОО

№	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Амьсгалын аппарат	ширхэг	1	30000000	30000000
2	Хүчилтөрөгч өтгөрүүлэгч	ширхэг	10	1450000	14500000
3	Хяналтын монитор	Ширхэг	5	3700000	18500000
4	Шүүлтүүртэй маск /И95/	Ширхэг	500	4500	2250000
5	Ор хөнжлийн даавуу	Ширхэг	160	25000	4000000
Нийт					69250000

-oOo-